



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 318

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.3, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ өртгөө нөхсөн, нийт 109,396,399.83 (нэг зуун есөн сая гурван зуун ерэн зургаан мянга гурван зуун ерэн есөн төгрөг наян гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баттөрд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, хоёрдогч түүхий эд болгон худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТ ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

Ц.ТҮВШИНЗАЯА



0000559

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 07 дугаар сарын 1-ний өдрийн 3.9 дугаар тогтоолын



"МИАТ" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Балансын дүн (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)
Эрүүл	1997/1998	ш	4	2,513,532.75	10,054,131.00	10,054,131.00
Эргүүл	1997/1998	ш	4	4,052,768.50	16,211,074.00	16,211,074.00
ийн, арлын гаар-136SO79101 үл ТГ/	2006/2006	ш	1	33,039,288.11	33,039,288.11	33,039,288.11
ен маркийн, н дугаар-NZBVO19873 лин ТГ/	2011/2011	ш	1	50,091,906.72	50,091,906.72	50,091,906.72
			10		109,396,399.83	109,396,399.83
ӨНГИЙН ДҮН			10 (арав)		109,396,399.83 (нэг зуун есөн сая гурван зуун ерэн зургаан мянга гурван зуун ерэн есөн төгрөг наян гурван мөнгө)	109,396,399.83 (нэг зуун есөн сая гурван зуун ерэн зургаан мянга гурван зуун ерэн есөн төгрөг наян гурван мөнгө)